МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

# ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

## 2024 оны I улирал

**/УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛЭЭР/**

Улаанбаатар хот,
2024 оны 04 сарын 05

**АГУУЛГА**

**БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**....4
1.1. Ачаа тээвэр....5
1.2. Зорчигч тээвэр....6
**БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР**....7
2.1. Ачаа тээвэр....7
2.1.1. Экспортын ачаа, боомтуудаар....8
2.1.2. Импортын ачаа, боомтуудаа....9
2.1.3. Ачааны нэр төрөл....10
2.1.4. Ачаа эргэлт, боомтуудаар....10
2.2. Зорчигч тээвэр....11
2.3. Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл....11
2.4. Тээврийн хэрэгслийн бүртгэл....12
**БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР**....15
3.1. Ачаа тээвэр....15
3.2. Зорчигч тээвэр....18
**БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР**....19
4.1. Ачаа тээвэр....19
4.2. Зорчигч тээвэр....20
4.2.2. Олон улсын зорчигч тээвэр....21
4.2.3. Орон нутгийн зорчигч тээвэр....22
4.3. Нислэг гүйцэтгэлийн мэдээ....23

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт....4
Хүснэгт 2. Автотээврийн ачаа....7
Хүснэгт 3. Автотээврийн ачааны экспорт, боомтуудаар....8
Хүснэгт 4. Автотээврийн ачааны импорт, боомтуудаар....9
Хүснэгт 5. Автотээврээр тээсэн ачааны нэр төрөл....10
Хүснэгт 6. Ачаа эргэлт, боомтуудаар....10
Хүснэгт 7. Автотээврийн зорчигч тээвэр....11
Хүснэгт 8. Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл....11
Хүснэгт 9. Тээврийн хэрэгслийн бүртгэл....12
Хүснэгт 10. Тээврийн хэрэгслийн төрөл, аймгаар....13
Хүснэгт 11. Төмөр замын ачаа тээвэр....15
Хүснэгт 12. Төмөр замын зорчигч тээвэр....18
Хүснэгт 13. Агаарын тээврийн ачаа....19
Хүснэгт 14. Агаарын тээврийн зорчигч....20
Хүснэгт 15. Олон улсын зорчигч тээвэр....21
Хүснэгт 16. Орон нутгийн зорчигч тээвэр....22
Хүснэгт 17. Нислэг гүйцэтгэлийн мэдээ....23

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Нийт ачаа тээвэр....5

Зураг 2. Нийт экспорт.....5
Зураг 3. Нийт импорт.....5
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....6
Зураг 5. Олон улсад зорчигч.....6
Зураг 6. Орон нутагт зорчигч.....6
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....7
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....7
Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн боомтоор.....8
Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....9
Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар.....10
Зураг 12. Автотээврээр зорчсон зорчигч.....11
Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....12
Зураг 14. Тээврийн хэрэгслийн төрөл.....13
Зураг 15. Тээврийн хэрэгслийн бүртгэл, аймгаар.....14
Зураг 16. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн.....15
Зураг 17. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь.....16
Зураг 18. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....16
Зураг 19. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....16
Зураг 20. УБТЗ-ын ачаа тээврийн 3 дугаар сарын хоногийн мэдээ.....16
Зураг 21. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....17
Зураг 22. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....17
Зураг 23. Төмөр замын зорчигч тээвэр.....18
Зураг 24. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор.....18
Зураг 25. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....19
Зураг 26. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....19
Зураг 27. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....19
Зураг 28. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....20
Зураг 29. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....20
Зураг 30. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....21
Зураг 31. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....22
Зураг 32. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....22
Зураг 33. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....23
Зураг 34. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....23

Боловсруулсан: Зам, тээврийн хөгжлийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа,
стандарт, статистикийн хэлтэс

# БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ[1]

*Хүснэгт 1*

| № | Үзүүлэлт | Тээврийн төрөл | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 03 дугаар сар | I улирал | 03 дугаар сар | I улирал | |
| 1 | **Тээвэрлэсэн ачаа** | Автотээвэр | *мян.тн* | 6912.07 | 14,462.6 | 7,336.3 | 17,776.4 | 22.9% |
| | | Төмөр зам | *мян.тн* | 3173.3 | 9,393.0 | 3,687.4 | 10,675.3 | 13.7% |
| | | Агаар | *мян.тн* | 0.79 | 2.20 | 0.77 | 2.19 | -0.4% |
| | | **Нийт ачаа** | ***мян.тн*** | **10,086.2** | **23,857.8** | **11,024.5** | **28,453.9** | **19.3%** |
| 2 | **Дамжин өнгөрөх ачаа /транзит/** | **Төмөр зам** | *мян.тн* | 435.2 | 1,119.5 | 399.6 | 10,675.3 | 853.6% |
| 3 | **Ачаа гаргалт /экспорт/** | Төмөр зам | *мян.тн* | 971.6 | 2,879.3 | 945.1 | 2,695.2 | -6.4% |
| | | Автотээвэр | *мян.тн* | 6,766.3 | 14,181.5 | 7,141.5 | 17,340.0 | 22.3% |
| | | **Нийт** | *мян.тн* | **7,737.9** | **17,060.8** | **8,086.6** | **20,035.1** | 17.4% |
| 4 | **Ачаа оруулалт /импорт/** | Төмөр зам | *мян.тн* | 269.1 | 797.4 | 349.7 | 1,030.3 | 29.2% |
| | | Автотээвэр | *мян.тн* | 145.8 | 281.1 | 194.8 | 436.4 | 55.3% |
| | | **Нийт** | ***мян.тн*** | **414.9** | **1,078.5** | **544.5** | **1,466.7** | 36.0% |
| 5 | **Дотоодод тээвэрлэсэн ачаа** | Төмөр зам | *мян.тн* | 1,497.4 | 4,596.8 | 1,993.1 | 5,695.5 | 23.9% |
| | | Агаар | *мян.тн* | 0.79 | 2.20 | 0.77 | 2.19 | -0.4% |
| | | **Нийт** | ***мян.тн*** | **1,498.2** | **4,599.0** | **1,993.8** | **5,697.7** | 23.9% |
| 6 | **Ачаа эргэлт (сая тонн/ км)** | Автотээвэр | *сая тн/км* | 1,105.2 | 2,335.0 | 1,008.9 | 2,659.8 | 13.9% |
| | | Төмөр зам | *сая тн/км* | 1,597.5 | 4,567.8 | 1,570.6 | 4,779.0 | 4.6% |
| | | Агаар | *сая.тн/км* | 2.1 | 6.2 | 2.1 | 6.5 | 4.1% |
| | | **Нийт** | ***сая тн/км*** | **2,704.8** | **6,909.0** | **2,581.7** | **7,445.3** | 7.8% |
| 7 | **Зорчигчдын тоо** | Автотээвэр | *мян.хүн* | 12,912.8 | 33,040.7 | 12,924.9 | 33,881.2 | 2.5% |
| | | Төмөр зам | *мян.хүн* | 169.2 | 472.9 | 134.3 | 419.5 | -11.3% |
| | | Агаар | *мян.хүн* | 107.4 | 318.4 | 127.8 | 412.2 | 29.5% |
| | | **Нийт зорчигч** | ***мян.хүн*** | **13,189.4** | **33,832.0** | **13,187.1** | **34,712.9** | 2.6% |
| 8 | **Олон улсад зорчигчдын тоо** | Автотээвэр | *мян.хүн* | 61.3 | 107.1 | 45.5 | 99.1 | -7.5% |
| | | Төмөр зам | *мян.хүн* | 1.0 | 3.4 | 2.5 | 7.1 | 110.0% |
| | | Агаар | *мян.хүн* | 75.4 | 229.3 | 95.6 | 315.0 | 37.4% |
| | | **Нийт** | ***мян.хүн*** | **137.6** | **339.8** | **143.6** | **421.3** | 24.0% |
| 9 | **Орон нутагт зорчигчдын тоо** | Автотээвэр | *мян.хүн* | 103.1 | 345.7 | 109.8 | 416.4 | 20.5% |
| | | Төмөр зам | *мян.хүн* | 168.2 | 469.5 | 131.9 | 412.4 | -12.2% |
| | | Агаар | *мян.хүн* | 32.0 | 89.1 | 32.1 | 97.1 | 9.1% |
| | | **Нийт** | ***мян.хүн*** | **303.3** | **904.3** | **273.7** | **925.9** | 2.4% |
| 10 | **Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо** | Автотээвэр | *мян.хүн* | 12,748.5 | 32,587.9 | 12,769.7 | 33,365.7 | 2.4% |
| 11 | **Зорчигч эргэлт** | Автотээвэр | *сая хүн/ км* | 166.1 | 486.2 | 170.5 | 539.2 | 10.9% |
| | | Төмөр зам | *сая хүн/ км* | 60.6 | 159.5 | 58.0 | 172.8 | 8.3% |
| | | Агаар | *сая хүн/ км* | 222.31 | 742.35 | 277.51 | 1,004.97 | 35.4% |
| | | **Нийт** | ***сая хүн/км*** | **449.0** | **1,388.1** | **505.9** | **1,717.0** | 23.7% |

[1] *Зам, тээврийн салбарын 2024 оны 03 дугаар сар болон эхний улирлын статистикийн мэдээг урьдчилсан гүйцэтгэлээр “Салбарын нэгдсэн платформ”-оос нэгтгэн 2024 оны 04 дүгаар сарын 05-ны өдөр гаргав.*

## 1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2024 оны 03 дугаар сард 11 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.1%-аар өссөн байна. Харин 1 дүгээр улиралд 28.5 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны 1 дүгээр улирлаас 19.3%-аар өссөн байна.

- 2024 оны 3 дугаар сард автотээврээр 7.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.1%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.1 сая тонн ачаа (+5.5%), импортоор 194.8 мянган тонн ачаа (+33.6%) тээвэрлэсэн байна. Эхний улирлын байдлаар нийт 17.8 сая тонн ачаа тээсэн нь 22.9%-аар, экспортын ачаа 17.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 22.3%-аар, импортын ачаа 436.4 мянган тонн болж 55.3%-аар тус тус өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2024 оны 3 дугаар сард нийт 3.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.2%-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 2 сая тонн (+33.1%), импортын ачаа 349.7 мянган тонн (+30%), экспортын ачаа 945.1 мянган тонн (-2.7%), дамжин өнгөрсөн ачаа 399.6 мянган тонн (-8.2%) тээвэрлэсэн байна. Эхний улиралд нийт 10.7 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 13.7%-аар өссөн. Үүнд дотоодын ачаа 5.7 сая тонн (+23.9%), импортын ачаа 1 сая тонн (+29.2%), дамжин өнгөрсөн ачаа 1.3 сая тонн (+12%), экспортын ачаа 2.7 сая тонн (-6.4%) тээвэрлэсэн байна.
- Агаарын тээврээр 2024 оны 3 дугаар сард 773.9 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5%-аар буурсан. Үүнээс ачаа 753.8 тонн (+18.2%), шуудан 20.1 тонн (-87.1%) байна. Харин I улиралд 2191.8 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны I улирлаас 0.4%-аар буурсан байна. Үүнээс ачаа 2133 тонн (+19,7%), нийт шуудан 58.8 тонн (-86%) тээвэрлэсэн байна.

**Зураг 1. Нийт ачаа тээвэр, мян.тонн**




**Зураг 2. Нийт экспорт**




3 дугаар сард экспортоор 8.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 4.5%-аар өссөн байна. Харин 2024 оны эхний улиралд экспортын хэмжээ 20 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 17.4%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 2.7 сая тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.4%-аар буурсан бол автотээврээр 17.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 22.3%-аар өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 87%-ийг, төмөр зам 13%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2024 оны 3 дугаар сард нийт 544.5 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 31.3%-аар өссөн. Эхний улиралд нийт 1.5 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс +36%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 1 сая тонн ачаа импортолсон нь 29.2%-аар, автотээврээр 436.4 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 55.3%-аар тус тус өссөн байна. Төмөр замаар 70%-ийг, автотээврээр 30%-ийг тээсэн байна. /Зураг 3/

**Зураг 3. Нийт импорт**



## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2024 оны 03 дугаар сард 13.2 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэтэй адил байгаа бол 2024 оны эхний улиралд 34.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.6%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Авто тээврээр 2024 оны 3 дугаар сард 12.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.1%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 45496 зорчигч (-25.8%), орон нутагт 109753 зорчигч (+6.5%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 12.7 сая зорчигч (+0.2%) тус тус зорчсон байна. Эхний улиралд нийт 33.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.5%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 33.4 сая зорчигч (+2.4%), орон нутагт 416 мянган зорчигч (+20.5%), олон улсад 99.1 мянган зорчигч (-7.5%) зорчсон. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- 2024 оны 3 дугаар сард нийт 134.3 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 20.6%-аар буурсан. Үүнээс олон улсад 2.48 мянган зорчигч (*2.5), орон нутагт 131.9 мянган зорчигч (–21.6%) зорчсон байна. Эхний улиралд нийт 419.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11.3%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 7.1 мянган зорчигч (*2.1), орон нутагт 412.4 мянган зорчигч (-12.2%) тус тус зорчоод байна.
- 2024 оны 3 дугаар сард агаарын тээврээр нийт 127.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 3 дугаар сараас 19%-аар өссөн. Үүнээс олон улсад 95.6 мянган зорчигч зорчиж (+26.9%), орон нутагт 32.1 мянган зорчигч зорчиж (+0.4%)-аар тус тус зорчсон байна. Эхний 1 дүгээр улиралд нийт 412.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 29.5%-аар өссөн бол үүнээс олон улсад 315 мянган зорчигч (+37.4%), орон нутагт 97.1 мянган зорчигч (+9.1%) тус тус зорчоод байна.

**Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн**




**Зураг 5. Олон улсад зорчигч**




2024 оны эхний 1-р улиралд олон улсад нийт 421.3 мянган зорчигч (+24%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 315 мянган зорчигч (+37.4%), автотээврээр 99.1 мянган зорчигч (-7.5%), төмөр замаар 7.1 мянган зорчигч (+110%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дунд агаарын тээвэр 75%, автотээвэр 23%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2024 оны эхний 1-р улиралд орон нутагт нийт 925.6 мянган зорчигч (+2.4%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 416.4 мянган зорчигч (+20.5%), төмөр замаар 412.4 мянган зорчигч (-12.2%), агаарын тээврээр 97.1 мянган зорчигч (+9.1%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дунд агаарын тээвэр 9.3%, автотээвэр 48.3%, төмөр зам 42.4%-ийг эзэлж байна. /Зураг 6/

**Зураг 6. Орон нутагт зорчигч**



# БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

## 2.1. АЧАА ТЭЭВЭР

**2024 оны эхний улиралд авто замаар нийт 17.5 сая тонн ачаа тээвэрлэснээс 17.3 сая тонн ачаа экспортолсон байна.**

*Хүснэгт 2*

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралт |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3 сар | I улирал | 3 сар | I улирал | |
| **Нийт ачаа тээвэр** | **тонн** | **6,912,069.0** | **14,462,578.0** | **7,336,283.0** | **17,776,400.4** | **22.9%** |
| Ачааны импорт | тонн | 145,764.0 | 281,069.0 | 194,813.0 | 436,432.4 | 55.3% |
| Ачааны экспорт | тонн | 6,766,305.0 | 14,181,509.0 | 7,141,470.0 | 17,327,694.9 | 22.3% |
| Ачаа эргэлт | тн.км | 1,105,238,273.0 | 2,335,012,035.0 | 1,008,916,744.0 | 2,659,818,160.4 | 13.9% |

2024 оны 3 дугаар сард автотээврээр 7.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.1%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.5%-аар, импортоор 194.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 33.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 3 дугаар сард 1 тэрбум тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 8.7%-аар буурсан байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.

**Зураг 7 . Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар**




Эхний улирлын байдлаар нийт 17.8 сая тонн ачаа тээсэн нь 22.9%-аар, экспортын ачаа 17.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 22.3%-аар, импортын ачаа 436.4 мянган тонн болж 55.3%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 2.7 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 13.9%-аар өссөн байна.

2024 оны эхний улирлын байдлаар нийт ачаа тээврийн 17.3 сая тонн буюу 97.5%-ийг экспортын ачаа, 436.4 мянган тонн буюу 2.5%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 55%-ийг бүрдүүлж байна. Харин импортын ачааны 76%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа эзэлж байна. /Зураг 8/

**Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь**



## 2.1.1. ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

*Хүснэгт 3*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3 сар | I улирал | 3 сар | I улирал | |
| 1 | **Нийт ачаа тээвэр** | тонн | **6,912,069.0** | **14,462,578.0** | **7,336,283.0** | **17,776,400.4** | 22.9% |
| 2 | **Ачааны экспорт-боомтуудаар** | **тонн** | **6,766,305.0** | **14,181,509.0** | **7,141,470.0** | **17,339,968.0** | 22.3% |
| 3 | ОХУ-руу | тонн | 13,023.0 | **31,232.0** | 3,617.0 | **12,273.1** | -60.7% |
| 4 | Алтанбулаг | тонн | 6,068.0 | **10,088.0** | 3,617.0 | **12,273.1** | 21.7% |
| 5 | Боршоо | тонн | 0.0 | **0.0** | 0.0 | **0.0** | - |
| 6 | Цагаан нуур | тонн | 6,955.0 | **21,144.0** | 0.0 | **0.0** | -100.0% |
| 7 | БНХАУ-руу | тонн | **6,753,282.0** | **14,150,277.0** | **7,137,853.0** | **17,327,694.9** | 22.5% |
| 8 | Бичигт | тонн | 148,459.0 | **341,033.0** | 157,743.0 | **401,951.0** | 17.9% |
| 9 | Баянхошуу | тонн | 379,690.0 | **473,321.0** | 40,957.0 | **126,649.6** | -73.2% |
| 10 | Бургастай | тонн | 94,503.0 | **131,061.0** | 53,038.0 | **139,746.0** | 6.6% |
| 11 | Булган | тонн | 479,411.0 | **701,005.0** | 306,039.0 | **627,640.0** | -10.5% |
| 12 | Гашуунсухайт | тонн | 3,163,363.0 | **7,586,132.0** | 3,480,574.0 | **9,565,267.6** | 26.1% |
| 13 | Замын-Үүд | тонн | 447,031.0 | **472,168.0** | 88,859.0 | **219,532.0** | -53.5% |
| 14 | Ханги | тонн | 509,661.0 | **1,098,277.0** | 745,381.0 | **1,766,511.7** | 60.8% |
| 15 | Хавирга | тонн | 13,961.0 | **17,634.0** | 9,453.0 | **9,453.0** | -46.4% |
| 16 | Шивээ хүрэн | тонн | 1,517,203.0 | **3,329,646.0** | 2,255,809.0 | **4,470,944.0** | 34.3% |
| 17 | Сүмбэр | тонн | 0.0 | **0.0** | 0.0 | **0.0** | - |

2024 оны 3 дугаар сард автотээврээр экспортод 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.2%-аар өссөн байна. Харин эхний улирлын байдлаар экспортын ачаа 17.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 21.6%-аар өссөн байна. Үүнд Бичигт, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдсэн нь нийт экспортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

**Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор**




ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2024 оны 3 сард 3.6 мянган тонн ачаа, харин эхний улирлын байдлаар 12.3 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оноос 60.7%-аар буурсан байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтуудоор 3 сард 7.1 сая тонн ачаа, харин эхний улирлын байдлаар бол 17.3 сая тонн ачаа гарсан нь 22.5%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачаа Гашуунсухайт боомтоор 9.6 сая тонн (+26.1%) буюу нийт экспортын 55%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 4.5 сая тонн (+34.3%), Ханги боомтоор 1.8 сая тонн (+60.8%), Булган боомтоор 3627.6 мянган тонн (-10.5%), Бичигт боомтоор 402 мянган тонн (+17.9%), Замын-Үүд боомтоор 219.5 мянган тонн (-53.5%), Бургастай боомтоор 139.7 мянган тонн (+6.6%), Баянхошуу боомтоор 126.6 мянган тонн (-73.2%), Хавирга боомтоор 9.4 мянган тонн (-46.4%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/

## 2.1.2 ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

*Хүснэгт 4*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **1** | **Нийт ачаа тээвэр** | **тонн** | **6,912,069.0** | **14,462,578.0** | **7,336,283.0** | **17,776,400.4** | **22.9%** |
| 2 | Ачааны импорт –боомтуудаар | тонн | 145,764.0 | 281,069.0 | 194,813.0 | 436,432.4 | 55.3% |
| 3 | ОХУ-аас | тонн | 22,278.0 | 61,076.0 | 39,348.0 | 98,904.9 | 61.9% |
| 4 | Алтанбулаг | тонн | 11,867.0 | 33,096.0 | 18,916.0 | 42,262.9 | 27.7% |
| 5 | Боршоо | тонн | 1,385.0 | 3,732.0 | 5,172.0 | 14,434.0 | 286.8% |
| 6 | Цагаан нуур | тонн | 9,026.0 | 24,248.0 | 15,260.0 | 42,208.0 | 74.1% |
| 7 | БНХАУ-аас | тонн | 123,486.0 | 219,993.0 | 155,465.0 | 337,527.5 | 53.4% |
| 8 | Бичигт | тонн | 0.0 | 0.0 | 508.0 | 1,593.0 | - |
| 9 | Баянхошуу | тонн | 651.0 | 1,169.0 | 0.0 | 0.0 | -100.0% |
| 10 | Бургастай | тонн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |
| 11 | Булган | тонн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |
| 12 | Гашуунсухайт | тонн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |
| 13 | Замын-Үүд | тонн | 122,498.0 | 218,451.0 | 152,521.0 | 333,460.5 | 52.6% |
| 14 | Ханги | тонн | 43.0 | 63.0 | 0.0 | 0.0 | -100.0% |
| 15 | Хавирга | тонн | 294.0 | 310.0 | 2,436.0 | 2,474.0 | 698.1% |
| 16 | Шивээ хүрэн | тонн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |

Автотээврээр 2024 оны 3 дугаар сард импортоор 194.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 33.6%-аар өссөн байна. Үүнээс 39.3 мянган тонныг ОХУ-аас, 155.5 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Харин эхний улирлын байдлаар импортын ачаа 436.4 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 55.3%-аар өссөн байна. Үүнд Боршоо, Цагааннуур, Замын-Үүд, Хавирга боомтуудаар орж ирсэн ачааны хэмжээ нэмэгдсэн нь нийт импортын ачааны өсөлтөд голлон нөлөөлжээ.

I улиралд ОХУ-аас 98.9 мянган тонн, БНХАУ-аас 337.5 мянган тонн ачаа оруулж ирсэн байна. Импортын ачааны 77%-ийг БНХАУ-аас, 23%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 76%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.**

БНХАУ-аас Замын-Үүд боомтоор 333.5 мянган тонн ачаа (+52.6%), Бичигт боомтоор 1.6 мянган тонн ачаа, Хавирга боомтоор 2.5 тонн ачаа оруулсан байна.

ОХУ-аас Алтанбулаг боомтоор 42.3 мянган тонн (+27.7%), Цагааннуур боомтоор 42.2 мянган тонн (+74.1%), Боршоо боомтоор 14.4 мянган тонн (+286.8%) ачаа тус тус орж иржээ. /Зураг 10/

**Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор**



## 2.1.3. АЧААНЫ НЭР ТӨРӨЛ

*Хүснэгт 5*

| Ачааны нэр төрлөөр | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| Нүүрс | *тонн* | 5,756,029.8 | 12,912,578.0 | 6,925,144.2 | 16,759,560.9 | 29.8% |
| Газрын тос | *тонн* | 52,276.4 | 145,689.3 | 40,956.6 | 126,649.2 | -13.1% |
| Зэсийн баяжмал | *тонн* | 69,440.0 | 161,800.0 | 63,622.7 | 215,625.7 | 33.3% |
| Төмрийн хүдэр | *тонн* | 94,502.7 | 131,060.7 | 67,802.6 | 159,270.3 | 21.5% |
| Жонш | *тонн* | 0.0 | 0.0 | 3,650.6 | 20,354.5 | - |
| Бусад | *тонн* | 794,056.1 | 830,381.0 | 40,293.3 | 71,836.5 | -91.3% |

Авто замын боомтуудаар гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл нүүрс 3 дугаар сард 6.9 сая тонн (+20.3%), зэсийн баяжмал 63.6 мянган тонн (-8.4%), газрын тос 41 мянган тонн (-21.7%), төмрийн хүдэр 67.8 мянган тонн (-23.8%), жонш 3.6 мянган тонн, бусад ачаа 40.3 мянган тонн ачаа гаргасан байна.

2024 оны эхний улирлын байдлаар нийт нүүрс 16.8 сая тонн (+29.8%), зэсийн баяжмал 215.6 мянган тонн (+33.3%), төмрийн хүдэр 159.3 мянган тонн (+21.5%), газрын тос 126.6 мянган тонн (-13.1%), жонш 20.3 мянган тонн, бусад 71.8 мянган тонн ачаа тус тус экспортолсон байна. /Зураг 11/

**Зураг 11 .Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар**




## 2.1.4. АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР

*Хүснэгт 6*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **1** | **Нийт ачаа эргэлт** | **тн.км** | **1,105,238,273.0** | **2,335,012,035.0** | **1,008,916,744.0** | **2,659,818,160.4** | **13.9%** |
| 2 | Алтанбулаг | тн.км | 412,505.0 | 993,232.0 | 518,259.0 | 1,254,326.9 | 26.3% |
| 3 | Бичигт | тн.км | 11,876,720.0 | 27,282,640.0 | 12,660,080.0 | 32,283,520.0 | 18.3% |
| 4 | Баянхошуу | тн.км | 243,418,240.0 | 303,673,600.0 | 26,212,480.0 | 81,055,744.0 | -73.3% |
| 5 | Бургастай | тн.км | 7,560,240.0 | 10,484,880.0 | 4,243,040.0 | 11,179,680.0 | 6.6% |
| 6 | Гашуунсухайт | тн.км | 727,573,490.0 | 1,744,810,360.0 | 800,532,020.0 | 2,200,011,548.0 | 26.1% |
| 7 | Замын-Үүд | тн.км | 3,986,703.0 | 4,834,333.0 | 1,689,660.0 | 3,870,947.5 | -19.9% |
| 8 | Цагаан нуур | тн.км | 1,598,100.0 | 4,539,200.0 | 1,526,000.0 | 4,220,800.0 | -7.0% |
| 9 | Ханги | тн.км | 10,194,080.0 | 21,966,800.0 | 14,907,620.0 | 35,330,234.0 | 60.8% |
| 10 | Шивээ хүрэн | тн.км | 98,618,195.0 | 216,426,990.0 | 146,627,585.0 | 290,611,360.0 | 34.3% |

2024 оны эхний улирлын байдлаар автотээврийн ачаа эргэлт нийт 2.7 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 13.9%-аар өссөн байна. Үүнээс ачаа эргэлт хамгийн их байгаа боомт болох Гашуунсухайтаар 2.2 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 83%-ийг дангаар бүрдүүлж байна. Харин хамгийн их өсөлттэй байгаа боомт нь Ханги буюу тус боомтоор 35 сая тонн км ачаа эргэлт хийсэн нь өмнөх оны 1-р улирлаас 60.8%-аар өссөн байна. /Хүснэгт 6/

## 2.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

**Автотээврээр эхний улиралд 33.9 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5%-аар өссөн байна.**

*Хүснэгт 7*

| Зорчигч тээвэр | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **Нийт зорчигч тээвэр** | *хүн* | **12,912,835.0** | **33,040,701.0** | **12,924,947.0** | **33,881,219.0** | **2.5%** |
| Олон улсад зорчигчид | *хүн* | 61,286.0 | 107,080.0 | 45,496.0 | 99,079.0 | -7.5% |
| Хот хоорондын зорчигч | *хүн* | 103,064.0 | 345,716.0 | 109,753.0 | 416,422.0 | 20.5% |
| Хот доторх нийтийн тээврээр зорчигч | *хүн* | 12,748,485.0 | 32,587,905.0 | 12,769,698.0 | 33,365,718.0 | 2.4% |
| Зорчигч эргэлт | *сая хүн.км* | 166.13 | 486.23 | 170.5 | 539.2 | 10.9% |

**Зураг 12. Автотээврээр зорчсон зорчигч**




Авто тээврээр 2024 оны 3 дугаар сард 12.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.1%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 45496 зорчигч (-25.8%), орон нутагт 109753 зорчигч (+6.5%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 12.7 сая зорчигч (+0.2%) тус тус зорчсон байна.

Эхний улиралд нийт 33.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.5%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 33.4 сая зорчигч (+2.4%), орон нутагт 416 мянган зорчигч (+20.5%), олон улсад 99.1 мянган зорчигч (-7.5%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.5%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.2%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 12/

## 2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

*Хүснэгт 8*

| Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|
| | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| | **71,671** | **162,051** | **81,294** | 208,580.0 | 28.7% |
| **Орсон тээврийн хэрэгсэл** | 6,816 | **13,977** | 8,921 | 41,497.0 | 196.9% |
| БНХАУ-аас | 5,326 | **10,240** | 6,791 | 35,862.0 | 250.2% |
| Бичигт | 0 | 0 | 0.0 | 0.0 | - |
| Баянхошуу | 32 | 73 | 0.0 | 0.0 | -100.0% |
| Булган | 133 | 133 | 0.0 | 0.0 | -100.0% |
| Бургастай | 0 | 2 | 0.0 | 0.0 | -100.0% |
| Гашуунсухайт | 270 | 784 | 174.0 | 539.0 | -31.3% |
| Шивээхүрэн | 30 | 67 | 244.0 | 21,001.0 | 31244.8% |
| Замын-Үүд | 4,852 | 9,168 | 6,285.0 | 14,018.0 | 52.9% |
| Ханги | 1 | 1 | 40.0 | 140.0 | 13900.0% |
| Хавирга | 8 | 12 | 48.0 | 164.0 | 1266.7% |
| ОХУ-аас | 1,490 | **3,737** | 2,130 | 5,635.0 | 50.8% |
| Алтанбулаг | 843 | **2,243** | 1,109.0 | 2,673.0 | 19.2% |
| Боршоо | 60 | **170** | 218.0 | 617.0 | 262.9% |
| Цагааннуур | 587 | **1,324** | 803.0 | 2,345.0 | 77.1% |
| **Гарсан тээврийн хэрэгсэл** | 64,855 | **148,074** | 72,373 | 167,083.0 | 12.8% |
| БНХАУ-руу | 50,902 | **111,897** | 69,851 | 160,852.0 | 43.8% |
| Бичигт | 0 | **0** | 2,141.0 | 5,432.0 | - |
| Баянхошуу | 1,428 | **3,997** | 1,175.0 | 3,621.0 | -9.4% |
| Булган | 4,250 | **7,261** | 4,199.0 | 8,603.0 | 18.5% |
| Бургастай | 1,656 | **2,287** | 1,634.0 | 4,484.0 | 96.1% |
| Гашуунсухайт | 23,789 | **57,128** | 33,150.0 | 75,664.0 | 32.4% |
| Шивээхүрэн | 11,864 | **24,363** | 17,703.0 | 38,533.0 | 58.2% |
| Замын-Үүд | 754 | **1,614** | 1,389.0 | 3,465.0 | 114.7% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Ханги | 7,006 | **15,046** | 8,349.0 | 20,939.0 | 39.2% |
| | Хавирга | 155 | **201** | 111.0 | 111.0 | -44.8% |
| | Сүмбэр | 0 | **0** | 0.0 | 0.0 | - |
| ОХУ-руу | | 13,953 | **36,177** | 2,522 | 6,231.0 | -82.8% |
| | Алтанбулаг | 13,229 | **34,409** | 915.0 | 2,397.0 | -93.0% |
| | Боршоо | 56 | **144** | 212.0 | 614.0 | 326.4% |
| | Цагааннуур | 668 | **1,624** | 1,395.0 | 3,220.0 | 98.3% |

**Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл**




Монгол Улсын авто замын боомтуудаар 2024 оны 3 дугаар сард нийт 81294 ачаатэй тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд үүнээс 8921 тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны мөн үеэс 30.9%-аар, 72373 тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны мөн үеэс 11.6%-аар тус тус өссөн байна. /Хүснэгт 8/

Оны эхнээс өссөн дүнгээр буюу эхний улиралд нийт 208580 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 28.7%-аар өссөн байна. Үүнээс орсон ачаа тээврийн хэрэгсэл 41497 буюу 3 дахин, гарсан тээврийн хэрэгсэл 167083 болж өмнөх оны мөн үеэс 12.8%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 13/

## 2.4. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

*Хүснэгт 9*

| | 2023.03.31-ний өдрийн байдлаар | | 2024.03.31-ний өдрийн байдлаар | | Өсөлт % |
|---|---|---|---|---|---|
| **Төрөл** | **Улаанбаатар** | **Нийт** | **Улаанбаатар** | **Нийт** | **Өсөлт %** |
| Суудал | 453737 | 728431 | 523728 | 812286 | 11.5% |
| Ачаа | 76537 | 185429 | 85450 | 198886 | 7.3% |
| Автобус | 11621 | 22169 | 13138 | 24056 | 8.5% |
| Тусгай | 6352 | 9790 | 7113 | 10786 | 10.2% |
| Цистерн | 2611 | 3743 | 3021 | 4297 | 14.8% |
| Зүтгүүр | 23367 | 43802 | 27524 | 50506 | 15.3% |
| Механизм | 10790 | 15415 | 12211 | 17453 | 13.2% |
| Чиргүүл | 33730 | 64148 | 41327 | 75911 | 18.3% |
| Мотоцикл | 6286 | 28190 | 7968 | 31836 | 12.9% |
| **Нийт** | **625031** | **1101117** | **721480** | **1226017** | 11.3% |
| Баруун | 391863 | 636718 | 455604 | 713528 | 12.1% |
| Зүүн | 182367 | 356668 | 204397 | 387355 | 8.6% |
| **Нийт** | **574230** | **993386** | **660001** | **1100883** | 10.8% |
| Бензин | 217786 | 401626 | 234096 | 423242 | 5.4% |
| Дизель | 135882 | 286421 | 151994 | 310655 | 8.5% |
| Цахилгаан | 649 | 728 | 1042 | 1172 | 61.0% |
| Газ | 8202 | 13806 | 8685 | 14494 | 5.0% |
| Хосолсон | 227303 | 332095 | 282857 | 398250 | 19.9% |
| **Нийт** | **589822** | **1034676** | **678674** | **1147813** | 10.9% |
| 0-3 | 28013 | 45797 | 48144 | 74557 | 62.8% |
| 4-6 | 23659 | 47663 | 28155 | 53664 | 12.6% |
| 7-9 | 53076 | 76654 | 80550 | 109668 | 43.1% |
| 10 ба түүнээс дээш | 520284 | 931004 | 564632 | 988129 | 6.1% |
| **Нийт** | **625032** | **1101118** | **721481** | **1226018** | 11.3% |
| 1500 см3 хүртэл | 177982 | 336695 | 190512 | 354389 | 5.3% |
| 1501-2500 см3 | 240551 | 406855 | 292437 | 470547 | 15.7% |
| 2501-3500 см3 | 73541 | 132946 | 85423 | 147509 | 11.0% |
| 3501-4500 см3 | 26249 | 42792 | 29019 | 46266 | 8.1% |
| 4501 см3 дээш | 71092 | 115042 | 79785 | 127304 | 10.7% |
| Нийт | 589415 | 1034330 | 677176 | 1146015 | 10.8% |

2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад нийт 1 226 017 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас Улаанбаатар хотод 721 480 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Өмнөх онтой харьцуулахад нийт тээврийн хэрэгсэл 11.3%-аар нэмэгдсэн бол Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгсэл 15.4%-аар нэмэгдсэн байна. /Хүснэгт 9 /

**Зураг 14. Тээврийн хэрэгслийн төрөл,**




Нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн төрлөөр нь эзлэх жинг тооцвол суудлын 812286 буюу 66%, ачааны 198886 буюу 16%, чиргүүл 75911 буюу 6%, зүтгүүр 50506 буюу 4%, мотоцикл 31836 буюу 3%, автобус 24056 буюу 2%, механизм 17453 буюу 2%, тусгай зориулалтын 10786 буюу 1%, цистерн 4297 буюу 0.4%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 14/

## Тээврийн хэрэгслийн төрөл, аймгаар

*Хүснэгт 10*

| Төрөл | Суудал | Ачаа | Автобус | Тусгай | Цистерн | Зүтгүүр | Механизм | Чиргүүл | Мотоцикл | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Говьсүмбэр** | 2763 | 814 | 80 | 65 | 41 | 71 | 57 | 116 | 195 | **4202** |
| **Дундговь** | 7811 | 3788 | 328 | 124 | 32 | 30 | 86 | 60 | 1738 | **13997** |
| **Говь-Алтай** | 9217 | 3191 | 598 | 93 | 23 | 57 | 83 | 119 | 1658 | **15039** |
| **Булган** | 9036 | 5438 | 177 | 82 | 28 | 13 | 103 | 97 | 756 | **15730** |
| **Сүхбаатар** | 9844 | 4986 | 282 | 67 | 29 | 884 | 49 | 1115 | 663 | **17919** |
| **Завхан** | 10403 | 5881 | 429 | 126 | 45 | 40 | 84 | 152 | 951 | **18111** |
| **Хэнтий** | 12367 | 5708 | 419 | 124 | 34 | 64 | 142 | 260 | 771 | **19889** |
| **Баянхонгор** | 13454 | 4207 | 676 | 207 | 47 | 114 | 153 | 190 | 1274 | **20322** |
| **Архангай** | 11971 | 7714 | 316 | 104 | 13 | 38 | 80 | 155 | 422 | **20813** |
| **Төв** | 11642 | 7729 | 294 | 120 | 62 | 43 | 350 | 155 | 937 | **21332** |
| **Дорнод** | 13516 | 4946 | 489 | 161 | 89 | 296 | 223 | 438 | 1273 | **21431** |
| **Увс** | 12755 | 4977 | 530 | 145 | 40 | 89 | 144 | 200 | 2937 | **21817** |
| **Ховд** | 14500 | 4959 | 606 | 161 | 50 | 2008 | 224 | 2240 | 1057 | **25805** |
| **Баян-Өлгий** | 16776 | 4623 | 938 | 207 | 54 | 160 | 137 | 328 | 2877 | **26100** |
| **Дорноговь** | 15119 | 3938 | 729 | 231 | 111 | 3341 | 237 | 3533 | 474 | **27713** |
| **Өвөрхангай** | 16844 | 7266 | 554 | 141 | 37 | 307 | 272 | 635 | 1694 | **27750** |
| **Дархан-Уул** | 20716 | 5314 | 391 | 222 | 93 | 134 | 621 | 351 | 429 | **28271** |
| **Сэлэнгэ** | 17503 | 9068 | 349 | 195 | 60 | 264 | 629 | 552 | 1370 | **29990** |
| **Орхон** | 24246 | 4557 | 582 | 262 | 90 | 126 | 381 | 304 | 492 | **31040** |
| **Хөвсгөл** | 20118 | 8919 | 1068 | 260 | 73 | 198 | 191 | 383 | 1135 | **32345** |
| **Өмнөговь** | 17957 | 5413 | 1083 | 576 | 225 | 14705 | 996 | 23201 | 765 | **64921** |
| **Улаанбаатар** | 523728 | 85450 | 13138 | 7113 | 3021 | 27524 | 12211 | 41327 | 7968 | **721480** |
| **Нийт** | 812286 | 198886 | 24056 | 10786 | 4297 | 50506 | 17453 | 75911 | 31836 | **1226017** |

2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21 аймгуудад бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ангилвал Өмнөговь аймагт 64921 тээврийн хэрэгсэл хамгийн их бүртгэлтэй байгаа бол Говьсүмбэр аймагт 4202 тээврийн хэрэгсэл хамгийн бага бүртгэлтэй байна. /Зураг 15 /

**Зураг 15 .Тээврийн хэрэгслийн бүртгэл, аймгаар**




Автотээврийн техник хяналтын үзлэгт 2024 оны 1-р улирлын байдлаар Монгол Улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 206 641 тээврийн хэрэгсэл буюу 16.8% нь хамрагдсан байна.

# БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

## 3.1. АЧАА ТЭЭВЭР

**Төмөр замын тээврээр 2024 оны I улиралд нийт 10.7 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 13.7%-аар өслөө.**

*Хүснэгт 11*

| Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **Ачаа тээвэрлэлт** | | **мян.тн** | **3,173.3** | **9,393.0** | **3,687.4** | **10,675.3** | **13.7%** |
| | "Улаанбаатар төмөр зам" ХНН | мян.тн | 2,733.4 | 8,125.1 | 2,755.5 | 8,394.7 | 3.3% |
| | "Монголын төмөр зам" ТӨХК | мян.тн | 125.9 | 277.0 | 227.8 | 504.6 | 82.2% |
| | "Тавантолгой төмөр зам" ХХК | мян.тн | 60.0 | 156.3 | 294.9 | 643.5 | 311.7% |
| | "Монголиантранс Ложистик" ХХК | мян.тн | 254.0 | 834.6 | 346.2 | 990.0 | 18.6% |
| | "Монголиантранс Лайн" ХХК | мян.тн | 0.0 | 0.0 | 63.0 | 142.5 | - |
| Дотоодын ачаа | | мян.тн | 1,497.4 | 4,596.8 | 1,993.1 | 5,695.5 | 23.9% |
| | "Улаанбаатар төмөр зам" ХНН | мян.тн | 1,057.5 | 3,328.9 | 1,061.1 | 3,414.9 | 2.6% |
| үүнээс | "Монголын төмөр зам" ТӨХК | мян.тн | 125.9 | 277.0 | 227.8 | 504.6 | 82.2% |
| | "Тавантолгой төмөр зам" ХХК | мян.тн | 60.0 | 156.3 | 294.9 | 643.5 | 311.7% |
| | "Монголиантранс Ложистик" ХХК | мян.тн | 254.0 | 834.6 | 346.2 | 990.0 | 18.6% |
| | "Монголиантранс Лайн" ХХК | мян.тн | 0.0 | 0.0 | 63.0 | 142.5 | - |
| Импорт ачаа | | мян.тн | 269.1 | 797.4 | 349.7 | 1,030.3 | 29.2% |
| Экспорт ачаа | | мян.тн | 971.6 | 2,879.3 | 945.1 | 2,695.2 | -6.4% |
| Дамжин өнгөрөх ачаа | | мян.тн | 435.2 | 1,119.5 | 399.6 | 1,254.3 | 12.0% |
| Ачаа эргэлт | | сая.тн-км | 1,597.5 | 4,567.8 | 1,570.6 | 4,779.0 | 4.6% |

Төмөр замын тээврээр 2024 оны 3 дугаар сард нийт 3.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.2%-аар өслөө. Үүнээс дотоодын ачаа 2 сая тонн болж өмнөх оны 3 дугаар сараас 33.1%-аар, импортын ачаа 349.7 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 30%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 945.1 мянган тонн болж өмнөх оны 2 дугаар сараас 2.7%-аар, дамжин өнгөрсөн ачаа 399.6 мянган тонн болж 8.2%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 11/

Эхний улиралд нийт 10.7 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 13.7%-аар, дотоодын ачаа 5.7 сая тонн болж 23.9%-аар, импортын ачаа 1 сая тонн болж 29.2%-аар, дамжин өнгөрсөн ачаа 1.3 сая тонн болж 12%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 2.7 сая тонн болж өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 6.4%-аар буурсан байна. /Зураг 16/

**Зураг 16. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн**



**Зураг 17. Төмөр замын ачаа тээвэр, байгууллагуудын эзлэх хувь**




Эхний улирлын байдлаарх нийт ачаа тээврийн 8.4 сая тонн буюу 78.6%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 990 мянган тонн буюу 9.3%-ийн ачааг “Монголиантранс Ложистик” ХХК, 643.5 мянган тонн буюу 6%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 504.6 мянган тонн буюу 4.7%-ийн ачааг “Монголын төмөр зам” ТӨХК, 142.5 мянган тонн ачаа буюу нийт ачааны 1.3%-ийг “Монголиантранс Лайн” ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 17/

**Зураг 18. Төмөр замын ачаа тээврийн төрөл**




Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 5.7 сая тонн буюу 53%-ийг дотоодын ачаа, 2.7 сая тонн буюу 25%-ийг экспортын ачаа, 1.3 сая тонн буюу 12%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 1 сая тонн буюу 10%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 18/

**Зураг 19. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь**




Дотоодод тээвэрлэсэн 5.7 сая тонн ачааны 3.4 сая тонн ачаа буюу 60%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 990 мянган тонн ачаа буюу 17%-ийг “Монголиантранс Ложистик” ХХК, 643.5 мянган тонн буюу 11%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, 504.6 мянган тонн ачаа буюу 9%-ийг “Монголын төмөр зам” ТӨХК, “142.5 мянган тонн буюу 3%-ийг “Монголиантранс Лайн” ХХК тус тус эзэлж байна. /Зураг 19/

**Зураг 20. УБТЗ-ын ачаа тээврийн 3 дугаар сарын хоногийн мэдээ, 2024.03.01-2024.03.31**



“УБТЗ” ХНН-ийн ачаа тээврийн 3 дугаар сарын хоногийн мэдээг Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос оруулав. Үүнээс өдрийн дундажаас дээш ачаа тээвэрлэсэн өдрийг дурьдвал 2024.03.28-ний өдөр 50.3 мянган тонн экспортын ачаа, 2024.03.22-ны өдөр 43.5 мянган тонн дотоодын ачаа, 2024.03.18-ны өдөр 20.5 мянган тонн ачаа дамжин өнгөрсөн, 2024.03.17-ны өдөр 22.4 мянган тонн импортын ачаа тус тус ихээр тээвэрлэсэн нь графикаас харагдаж байна. /Зураг 20/

**Зураг 21 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор**




2024 оны эхний улирал буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.03.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. 1 дүгээр улиралд УБТЗ 2024.02.06-ны өдөр 112.8 мянган тонн хамгийн их ачаа тээсэн бол 2024.03.31-ний өдөр 68.2 мянган тонн хамгийн бага ачаа тээсэн байна. “МТЛожистик” ХХК нь 2024.02.04-ний өдөр 24.4 мянган тонн хамгийн их ачаа тээсэн бол 2024.01.10-ны өдөр тээвэрлэлт хийгээгүй байна. “ТТЗ” ХХК нь 2024.03.09-ний өдөр 16.7 мянган тонн хамгийн их ачаа тээсэн бол 2024.01.01,20, 2024.03.04,28-ны өдрүүдэд тээвэрлэлт хийгээгүй байна. “МТЗ” ТӨХК нь 2024.03.19-ний өдөр 13.7 мянган тонн хамгийн их ачаа тээсэн өдөр бол 2024.01.20-ны өдөр 245 тонн хамгийн бага ачаа тээсэн байна. “МТЛайн” ХХК 2024.02.18-ны өдөр хамгийн их 6.6 мянган тонн ачаа тээсэн байна. /Зураг21/

**Зураг 22. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар**




Байгууллагуудын ачаа тээвэрлэх хүчин чадал буюу ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход “УБТЗ” ХНН хоногт дундажаар 88.6 мянган тонн, “МТЛожистик” ХХК нь 11 мянган тонн, “ТТЗ” ХХК нь 7.4 мянган тонн, “МТЗ” ТӨХК нь 5.6 мянган тонн, “МТЛайн” ХХК нь хоногт дундажаар 3.3 мянган тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байна. /Зураг22/

## 3.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

**Төмөр замаар 2024 оны I улиралд 7.1 мянган зорчигч олон улсад тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 2.1 дахин өссөн байна.**

*Хүснэгт 12*

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2023 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **Зорчигч тээвэрлэлт** | ***мян.хүн*** | 169.2 | 472.9 | 134.3 | 419.5 | -11.3% |
| Олон улс | *мян.хүн* | 1.0 | 3.4 | 2.48 | 7.1 | 110.0% |
| Орон нутаг | *мян.хүн* | 168.2 | 469.5 | 131.9 | 412.4 | -12.2% |
| Зорчигч эргэлт | *сая хүн.км* | 60.6 | 159.5 | 57.97 | 172.8 | 8.3% |

2024 оны 3 дугаар сард нийт 134.3 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үеэс 20.6%-аар буурсан. Үүнээс олон улсад 2.48 мянган зорчигч зорчсон нь 2.5 дахин өссөн бол орон нутагт 131.9 мянган зорчигч зорсчон нь өмнөх оны мөн үеэс 21.6%-аар буурсан байна.

**Зураг 23. Төмөр замын зорчигч тээвэр**




Эхний улиралд нийт 419.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11.3%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 7.1 мянган зорчигч зорчсон нь 2.1 дахин өссөн бол харин орон нутагт 412.4 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.2%-аар буурсан байна.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь орон нутагт зорчих зорчигчдийн тоо тогтмол буурч байгаа бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна.

Нийт төмөр замаар зорчигчдийн 98% нь орон нутагт зорчсон бол 2% нь олон улсад зорчсон байна. /Зураг 23/

**Зураг 24. Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор**




2024 оны эхний улирал буюу 2024.01.01-ний өдрөөс 2024.03.31-ний өдөр хүртэл “УБТЗ” ХНН нь нийт 419.5 мянган зорчигч төмөр замаар тээвэрлэсэн байна. Эхний улирлын хоногийн дундажийг тооцоход төмөр замаар хоногт дундажаар 4491 зорчигч зорчоод байна. /Зураг 24/

# БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР
## 4.1 АЧАА ТЭЭВЭР

*Хүснэгт 13*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он 3 дугаар сар | 2023 он I улирал | 2024 он 3 дугаар сар | 2024 он I улирал | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Нийт ачаа, шуудан тээвэр** | *тн* | 794.0 | 2,201.2 | 773.88 | 2,191.8 | -0.4% |
| 2 | олон улсад | *тн* | 793.0 | 2,197.7 | 772.40 | 2,186.3 | -0.5% |
| 3 | орон нутагт | *тн* | 1.1 | 3.6 | 1.48 | 5.5 | 52.8% |
| 4 | **Нийт ачаа** | *тн* | 637.9 | 1,781.9 | 753.77 | 2,133.0 | 19.7% |
| 5 | олон улсад | *тн* | 637.3 | 1,779.5 | 752.29 | 2,127.6 | 19.6% |
| 6 | орон нутагт | *тн* | 0.57 | 2.4 | 1.48 | 5.5 | 129.4% |
| 7 | **Нийт шуудан** | *тн* | 156.1 | 419.4 | 20.11 | 58.8 | -86.0% |
| 8 | олон улсад | *тн* | 155.7 | 418.2 | 20.11 | 58.7 | -86.0% |
| 9 | орон нутагт | *тн* | 0.48 | 1.2 | 0 | 0 | -99.2% |
| 10 | **Ачаа эргэлт** | *мян.тн-км* | 2,099.0 | 6,232.7 | 2,148 | 6,485.5 | 4.1% |
| 11 | олон улсад | *мян.тн-км* | 2,098.0 | 6,229.5 | 2,147 | 6,482.2 | 4.1% |
| 12 | орон нутагт | *мян.тн-км* | 1.01 | 3.1 | 1.2 | 3.3 | 5.7% |

**Зураг 25. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан**




Агаарын тээврээр 2024 оны 3 дугаар сард 773.9 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5%-аар буурсан. Үүнээс ачаа 753.8 тонн болж өмнөх оны 3 дугаар сараас 18.2%-аар өссөн бол шуудан 20.1 тонн болж өмнөх оны мөн үеэс 87.1%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Харин I улиралд 2191.8 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны I улирлаас 0.4%-аар буурсан байна. Үүнээс ачаа 2133 тонн тээвэрлэсэн нь +19,7%-аар өссөн бол шуудан 58.8 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 86%-аар буурсан байна. /Зураг 25/

I улиралд олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 2186.3 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 0.5%-аар буурсан бол орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 5.5 тонн болж өмнөх оны мөн үеэс 52.8%-аар өссөн байна. /Зураг 26/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.7%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.3%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.4%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.6%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2024 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 6.5 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 4.1%-аар өссөн.

**Зураг 26. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан**




**Зураг 27. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар**



## 4.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

**Агаарын тээврээр 2024 оны эхний улиралд нийт 412.2 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 29.5%-аар өслөө.**

*Хүснэгт 14*

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **Нийт зорчигч тээвэр** | *хүн* | **107,361** | **318,361** | **127,771** | **412,177** | **29.5%** |
| Олон улсад | *хүн* | 75,355 | 229,307 | 95,643 | 315,036 | 37.4% |
| Орон нутагт | *хүн* | 32,006 | 89,054 | 32,128 | 97,141 | 9.1% |
| Зорчигч эргэлт | мян.хүн км | 222,307.7 | 742,353 | 277,513 | 1,004,969 | 35.4% |
| Олон улсад | мян.хүн км | 203,238 | 689,690 | 258,236 | 947,180 | 37.3% |
| Орон нутагт | мян.хүн км | 19,070 | 52,662 | 19,277 | 57,789 | 9.7% |

**Зураг 28. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо**




2024 оны 3 дугаар сард агаарын тээврээр нийт 127.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 19%-аар өссөн. Үүнээс олон улсад 95.6 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 26.9%-аар, орон нутагт 32.1 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 0.4%-аар тус тус өссөн байна.

Эхний 1 дүгээр улиралд нийт 412.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 29.5%-аар өссөн бол үүнээс олон улсад 315 мянган зорчигч зорчсон нь 37.4%-аар, орон нутагт 97.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 1-р улирлаас 9.1%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 14/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэн нь харагдаж байна./Зураг 29 /

**Зураг 29. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар**




Зорчигч эргэлт 2024 оны 1 дүгээр улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 1004 сая хүн км болж өмнөх оны мөн үеэс 35.4%-аар өссөн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 947.2 сая хүн км болж 37.3%-аар, орон нутгийн зорчигч эргэлт 57.8 сая хүн км болж 9.7%-аар тус тус өссөн байна.

## 4.2.1. ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

*Хүснэгт 15*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралт % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| 1 | **Нийт зорчигч тээвэр** | ***хүн*** | 107,361 | 318,361 | 127,771 | 412,177 | 29.5% |
| 2 | **Олон улсад** | ***хүн*** | 75,355 | 229,307 | 95,643 | 315,036 | 37.4% |
| 3 | чиглэл Сөүл | хүн | 34,343 | 100,565 | 31,569 | 100,191 | -0.4% |
| 4 | Токио | хүн | 6,988 | 18,397 | 9,380 | 24,090 | 30.9% |
| 5 | Франкфурт | хүн | 2,858 | 8,518 | 4,581 | 13,621 | 59.9% |
| 6 | Истанбул | хүн | 8,534 | 27,104 | 9,672 | 28,954 | 6.8% |
| 7 | Бээжин | хүн | 5,772 | 9,818 | 17,327 | 49,357 | 402.7% |
| 8 | Бангкок | хүн | 2,761 | 10,676 | 1,474 | 10,927 | 2.4% |
| 9 | Пукет | хүн | 1,377 | 6,320 | 378 | 7,900 | 25.0% |
| 10 | ХонКонг | хүн | 2,639 | 6,936 | 6,073 | 19,210 | 177.0% |
| 11 | Бусан | хүн | 2,012 | 6,278 | 2,027 | 6,511 | 3.7% |
| 12 | Фукуок | хүн | 170 | 3,894 | 1,491 | 17,819 | 357.6% |
| 13 | Алмата | хүн | 1,243 | 3,177 | 1,026 | 3,549 | 11.7% |
| 14 | Эрхүү | хүн | 723 | 1,929 | 1,305 | 3,332 | 72.7% |
| 15 | Улаан-Үд | хүн | 493 | 1,700 | 248 | 497 | -70.8% |
| 16 | Хөх хот | хүн | 1,030 | 1,753 | 2,189 | 7,558 | 331.1% |
| 17 | Манжуур | хүн | 107 | 107 | 1,037 | 2,393 | 2136.4% |
| 18 | Хайлаар/Хөлөнбуйр | хүн | | 0 | 1,595 | 3,690 | - |
| 19 | Хайкоу/Хайнань | хүн | | 0 | 1,013 | 2,455 | - |
| 20 | Фукуок - Ханой | хүн | 0 | 3,185 | 1,491 | 1,491 | -53.2% |
| 21 | Бусад | хүн | | 0 | 1,767 | 3,875 | - |

2024 оны эхний улиралд олон улсад нийт 315 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 37.4%-аар өссөн. Сөүл чиглэлд 100 мянган зорчигч (-0.4%), Бээжин хотруу 49.4 мянган зорчигч (+402.7%), Истанбул хотруу 28.9 мянган зорчигч (+6.8%), Токио чиглэлд 24.1 мянган зорчигч (+30.9%), ХонгКонг хотруу 19.2 мянган зорчигч (+177%), Фукуок чиглэлд 17.8 мянган зорчигч (+357.6%) тус тус тээвэрлэсэн байна. Үүнээс Манжуур, Бээжин, Фукуок, Хөх хот чиглэлд зорчигчийн тоо огцом нэмэгдсэн нь цар тахлын дараах аялал жуулчлал сэргэж эхэлсэн нь голлон нөлөөлжээ. /Зураг 30/

**Зураг 30. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр**



**Зураг 31. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь**




Олон улсад зорчсон зорчигчдын 161.3 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Korean Air”-ийн нислэгээр 29.6 мянга, “Airchina”-ийн нислэгээр 27.9 мянга, , “Хүнну Эйр” ХХК-ийн нислэгээр 21.2 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 18.5 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 18.1 мянга, “Изинис Эйрвейз” ХХК-ийн нислэгээр 11.8 мянга, Жэжү айр нислэгээр 12.2 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 9.9 мянга, Ираеро нислэгээр 3.8 мянган зорчигч, Красавиа нислэгээр 457, захиалгат нислэгээр 238 зорчигч зорчсон байна. /Зураг 31/

## 4.2.2. ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

*Хүснэгт 16*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 он 3 дугаар сар | 2023 он I улирал | 2024 он 3 дугаар сар | 2024 он I улирал | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Нийт зорчигч тээвэр** | *хүн* | **107,361** | **318,361** | **127,771** | **412,177** | 29.5% |
| 2 | **Орон нутагт зорчигч тээвэр** | *хүн* | **32,006** | **89,054** | **32,128** | **97,141** | **9.1%** |
| 3 | чиглэл Ховд | *хүн* | 750 | **1,867** | 988 | **2,724** | 45.9% |
| 4 | Улаангом | *хүн* | 154 | **451** | 280 | **586** | 29.9% |
| 5 | Алтай | *хүн* | 0 | **36** | 557 | **1,767** | 4808.3% |
| 6 | Оюутолгой | *хүн* | 30,021 | **84,141** | 28,164 | **85,635** | 1.8% |
| 7 | Оюутолгой/Даланзадгад | *хүн* | 0 | **0** | 36 | **410** | - |
| 8 | Мөрөн | *хүн* | 99 | **99** | 480 | **754** | 661.6% |
| 9 | Өлгий | *хүн* | 581 | **1,265** | 837 | **2,025** | 60.1% |
| 10 | Улиастай | *хүн* | 311 | **886** | 401 | **1,312** | 48.1% |
| 11 | Даланзадгад | *хүн* | 0 | **0** | 272 | **770** | - |
| 12 | Мөрөн/Улааангом | *хүн* | 0 | **0** | 113 | **909** | - |
| 13 | Бусад | | 0 | **0** | 0 | **193** | - |

**Зураг 32. Орон нутгийн зорчигч, чиглэлээр**




2024 оны 3 дугаар сард орон нутагт нийт 32.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 0.4%-аар өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр буюу эхний улиралд орон нутагт нийт 97.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.1%-аар өссөн бол Оюутолгой чиглэлд нийт 85.6 мянган зорчигч тээвэрлэсэн нь 1.8%-аар өссөн үзүүлэлттэй байна. Алтай болон Мөрөн чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн байна. /Хүснэгт 16/

**Зураг 33. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь**




2024 оны эхний 1 дүгээр улиралд агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 62% буюу 59.9 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 21% буюу 20.4 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 17% буюу 16.9 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутаг “МИАТ” ХХК-ийн зорчигч 19.1%-аар нэмэгдсэн бол, “Аэро Монголиа” ХХК зорчигч 5.6%-аар, “Хүнну эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 1.6%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 33/

## 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

*Хүснэгт 17*

| Үзүүлэлт | 2023 он | | 2024 он | | Өсөлт, бууралтын % |
|---|---|---|---|---|---|
| | 3 дугаар сар | I улирал | 3 дугаар сар | I улирал | |
| **Нийт нислэгийн тоо** | **4,035** | **10,528** | **6,473** | **18,987** | **80.3%** |
| Олон улсын өнгөрөлтийн нислэг | 2,742 | 7,014 | 5,080 | 14,772 | 110.6% |
| Хөөрөлт, буулт | 1,293 | 3,514 | 1,393 | 4,215 | 19.9% |
| Олон улсын хөөрөлт, буулт | 601 | 1,787 | 795 | 2,432 | 36.1% |
| Орон нутгийн хөөрөлт, буулт | 692 | 1,727 | 598 | 1,783 | 3.2% |

2024 оны 3 дугаар сард нийт нислэгийн тоо 6473 болж өмнөх оны мөн үеэс 60.4%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 5080 болж өмнөх оны мөн үеэс 85.3%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 795 болж 32.3%-аар өссөн бол орон нутгийн хөөрөлт, буултын тоо 598 болж 13.6%-аар буурсан байна.

2024 оны эхний улиралд нийт нислэгийн тоо 18987 болж өмнөх оны мөн үеэс 80.3%- аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 14772 болж өмнөх оны мөн үеэс 110.6%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 2432 болж 36.1%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 1783 болж өмнөх оны мөн үеэс 3.2%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 34/

**Зураг 34. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар**

